



III/2022

Тархаасан: 2022 оны 5 дугаар сарын 12




Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2022 оны 3 дугаар сард өмнөх сараас 11.1 хувиар өссөн байна

Гадаад худалдааны нөхцөлийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2022 оны 3 дугаар сард 199.1 болж, өмнөх оны мөн үеэс 19.8 хувь, өмнөх оны эцсээс 7.1 хувь, өмнөх сараас 11.1 хувиар тус тус өссөн байна.

Экспортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2022 оны 3 дугаар сард 235.0 болж, экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 36.8 хувь, өмнөх оны эцсээс 8.5 хувь, өмнөх сараас 12.9 хувиар тус тус өссөн байна. Экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 36.8 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 31.5 хувиар (зэсийн баяжмал, чулуун нүүрс, түүхий нефть) өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин өмнөх сараас 12.9 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 11.1 хувиар (төмрийн хүдэр, зэсийн баяжмал, чулуун нүүрс) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2022 оны 3 дугаар сард 118.0 болж, импортын үнэ өмнөх оны мөн үеэс 14.2 хувь, өмнөх оны эцсээс 1.3 хувь, өмнөх сараас 1.6 хувиар тус тус өссөн байна. Импортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 46.4 хувь (нефть), тээврийн хэрэгслийн бүлгийн үнэ 7.2 хувиар (суудлын машин) өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин өмнөх сараас 1.6 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 10.4 хувь (нефть), цаас картон тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүний бүлгийн үнэ 16.4 хувиар (хэвлэмэл материал) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 1. ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛИЙН ИНДЕКС¹ (2015=100), хувь



¹ Туршилт тооцоо

Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индексийг экспортын үнийн ерөнхий индексийг импортын үнийн ерөнхий индексэд харьцуулж тооцно.

Экспортын үнийн индекс: Монгол Улсын экспортын голлох худалдааны түнш орнуудад нийлүүлж буй барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

Импортын үнийн индекс: Монгол Улсын худалдааны түнш орнуудаас импортолж буй гол нэрийн барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.



Суурь үе: Индекс тооцоход хугацааны бусад үеийн үзүүлэлтэд харьцуулж тооцох хугацаа юм.

Эх үүсвэр:

Гаалийн Ерөнхий Газар

Ангилал:

Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 6 дугаар сарын 13

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Д.Мөнхтуул
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212